



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 09

Мөрөн

**Рашаан ашигласны төлбөрийн тухай**

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтуудыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Рашаан ашигласны төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай

Хоёр. Тухайн Рашааныг иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл хоршоо хариуцдаг бол тухайн эзэмшигчээс, эзэмшилгүй бол сумаас томилогдсон албан тушаалтан төлбөрийг төвлөрүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай

Гурав. Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар /Ч.Уртнасан/, Татварын хэлтэс /Т.Мөнхгэрэл / нарт даалгасугай


Дөрөв. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Рашаан ашигласны төлбөрийн тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 11-р сарын 17-ны өдрийн 103-р тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Т.БОЛДБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2013 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн  
09-р тогтоолын хавсралт



РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Төлбөр ноогдох рашаан	Хэмжих нэгж	Төлбөр /төгрөгөөр /	
			Халуун	Хүйтэн
1.	Эмчилгээ сувилгааны зориулалтаар ашиглахад	Хүн/ хоног	250	200
2.	Үйлдвэрлэл болон үйлчилгээний зориулалтаар ашиглахад	Шоо-метр	1000	2000